



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/247

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Нийтийн 2000м² зогсоол шинээр хийх (Булган сум) 3 дугаар багцын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан “Өвөлжөөнбулаг” ХХК-тай 73,025,421 (далан гурван сая хорин таван мянга дөрвөн зуун хорин нэг) төгрөгөөр гэрээ байгуулж, холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

2.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Өвөлжөөнбулаг” ХХК-ийн захирал (Б.Өлзийбаяр)-д үүрэг болгосугай.

3.Тус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Булган сумын Засаг дарга (Д.Бямбажаргал)-д даалгасугай.

4.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Авто замын сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (О.Сайнзаяа)-д зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025. оны
 04 дүгээр сарын 15-ны/ний өдрийн
 А/247 дугаар захирамжийн хавсралт

Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадлашгүй ажил	1 153 419	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	1 153 419	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	628 281	Ү.Бямбасүрэн
4	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	6 600 000	Ү.Бямбасүрэн
5	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 21 хоног	Ү.Бямбасүрэн
6	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	О.Сайнзаяа
7	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	О.Сайнзаяа Ү.Бямбасүрэн